



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 12 өдөр

дугаар 33

Улаанбаатар хот

Г Г
Журам боловсруулж батлуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.25, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 02 дугаар тэмдэглэл болон 2023 оны 09 дүгээр сарын 22-ний өдрийн эчнээс санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хяналтын зөвлөлөөс гаргасан 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн X3/01 дугаар саналыг хэлэлцэж шийдвэрлэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 02 дугаар тэмдэглэлээр Гүйцэтгэх захиралд даалгасан мөнгөн хөрөнгийн удирдлагын дотоод журмын төслийг боловсруулж, батлуулах ажлыг эрчимжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
2. Компанийн дотоод мөнгөн хөрөнгийн удирдлагын журам боловсруулахтай холбоотойгоор өндөр хүү санал болгосон, эрсдэл багатай арилжааны банкийг сонгон биржийн дэнчинг байршуулахтай холбостой харилцааг зохицуулсан журмын төслийг боловсруулж, мөнгөн хөрөнгийн удирдлагын журамтай хамт 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Төлөөлөн удирдах зөвлөлд ирүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.
3. Цаашид Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврыг тухай бүр биелүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д анхааруулсугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Н.Улаанхүү/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1522010087